

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн нэр:	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг:.....	3
1.3 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаархи товч мэдээлэл:	3
1.4 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харъяалал:	4
1.5 Төсөл хэрэгжиж буй орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил:	6
1.6 Үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо:	6
1.7 Үйл ажиллагааны хэд дэх жилдээ ажиллаж байгаа талаархи мэдээлэл:	6
1.8 Цаашид хэдэн жил үйл ажиллагаа явуулах боломжтой тухай :.....	7
1.9 Техник тоног төхөөрөмжийн тухай:.....	7
1.10 Технологийн дараалал:	9
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
2.1 Байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл	12
Үүсэж болох эрсдлийг тооцож, болзошгүй аюул ослын үед авах хариу арга хэмжээнүүд.....	13
Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ)	14
Байгаль орчны сургалт, сурталчилгаа:.....	15
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	15
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	17
5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	25
6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
7. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	29
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	33
9. Удирдлага зохион байгуулалтын	Error! Bookmark not defined.
10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	35
11. Календарь төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
12. Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
Хүснэгт 1. Машин техникийн жагсаалт	8
Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.	35
Хүснэгт 3. Гүйцэтгэлийн шалгуур.	Error! Bookmark not defined.
Зураг 1. Төслийн ерөнхий байршил	4
Зураг 2. Төслийн топо зураг.....	5

Зураг 3. Байршил.....	5
Зураг 4. Тэсрэх бодисын үйлдвэр, түүхий эдийн агуулахын зураг	10
Зураг 5. <i>Тэсрэх бодисын үйлдвэрийн дотоод зохион байгуулалт.</i>	11
Зураг 6. Флоу-чарт диаграм	11

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр:

“Спейшл Майнинг Сервис”ХХК-ний “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын цогцолбор”

1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг:

“Спейшл Майнинг Сервис” ХХК

Регистерийн дугаар: РД:5623529

Хаяг: Улаанбаатар хот , Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, “Рейжс Плейс” товер оффисын байр 17 давхар 1702 тоот

1.3 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаархи товч мэдээлэл:

“Спейшл майнинг сервис”ХХК-нь 2012 онд анх үүсгэн байгуулагдан худалдаа, ерөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлэх үндсэн үйл ажиллагаатайгаар эх орон болон бүс нутгийн хөгжилд хувь нэмэрээ оруулж байгаа аюулгүй ажиллагааг баримтлан, байгаль орчноо хайрлах, харилцагчийн эрх ашиг болон салбарын хөгжлийг дээдлэхийг эрхэмлэдэг үндэсний хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж юм.Манай компани нь 2013 оны 10 сард Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын цогцолбор”-ыг өөрийн хөрөнгөөр байгуулж, байгуулагдсан цагаас хойш уул уурхайн салбарт тэргүүлэн ажиллаж байгаа дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдтэй нягт хамтран ажилласаар ирсэн болно.2013- 2015 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Энержи Ресурс”ХХК, мөн “Таван толгой”ХК-иудад тэсэлгээний ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн.2015 оны 8 сараас Дархан Уул аймгийн “Шарын гол”ХК, 2015 оны 10 сараас 12 сард Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Өсөх зоос”ХХК-иудтай хамтран ажилласан. 2016-2017 онд улс орны эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотойгоор уул уурхайн салбар зогсонги байдалтай, хамтарч ажиллах байгууллага ховор байснаас тэсэлгээний ажил, үйлчилгээ хийгдээгүй бөгөөд зөвхөн тэсрэх бодис үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж дотоодын компаниудад бүтээгдэхүүнээ борлуулах ажлыг эрхлэн гүйцэтгэсэн. 2022 онд тэсрэх бодисын үйлдвэрлэл, борлуулалтын ажлыг гүйцэтгэхээс гадна Өмнөговь аймгийн Цогтцэций

суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс Таван Толгой”ХК-ний Цанхийн Баруун уурхай, орон нутгийн өмчит “Таван толгой”ХК-ний нүүрсний уурхай, Ноён суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Терра Энержи”ХХК-ний нүүрсний уурхайнуудын тэсэлгээний ажлыг гүйцэтгэн ажилласан.

1.4 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харъяалал:

“Спейшл Майнинг Сервис”ХХК-ний “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын цогцолбор” нь Таван Толгойн орд газрын лицензийн талбайд орших ба талбайн байршлыг байр зүйн зургаар үзүүлэв.

Зураг 1. Төслийн ерөнхий байршил



Таван Толгойн коксжих нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс баруун урагш 18 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн тийш 90 км, Улаанбаатар хотоос урагш 550 км-т оршино. Хилийн боомт болох Гашуун Сухайтаас хойш 240 км, Оюутолгойн зэс-алтны ордоос хойш 150км, Цагаан Суваргын зэс-молбидены ордоос баруун урд зүгт 234 км-т тус тус оршино

Зураг 2. Төслийн топо зураг



Зураг 3. Байршил



1.5 Төсөл хэрэгжиж буй орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил:

Цахилгаан, эрчим хүчний хангамжийн хувьд тэсрэх бодисын үйлдвэрийн бүхий л хэрэгцээг орд газрын эрчим хүчний эх үүсвэрээс авч хэрэглэж байна. Авто замын сүлжээний хувьд Өмнөговь аймгийн төв Даланзадгад, Цогт-Овоо сумыг холбосон засмал замаас Цогтцэций сум хүртэл 50км шороон замаар холбогдсон байдаг ба 2018-2019 онд засмал зам тавих ажил хийгдэж байгаа болно. Мөн эдгээрээс гадна харилцаа холбооны бүх төрлийн / үүрэн телефоны бүх сүлжээ, интернэт гэх мэт / үйлчилгээг ашиглах боломж нөхцөл бүрэн бүрдсэн болно.

1.6 Үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо:

“Спейшл Майнинг Сервис”ХХК-нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт “Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх” тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэгжүүлж буй “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын цогцолбор”-ын төсөл нь 2013 оны 9-р сараас эхлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2024 онд 11 дахь жилдээ төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

1.7 Үйл ажиллагааны хэд дэх жилдээ ажиллаж байгаа талаархи мэдээлэл:

Тус үйлдвэр нь 2024 онд 11 дахь жилдээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах бөгөөд 2018 онд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс Таван Толгой”ХК-ийн Цанхийн Зүүн уурхайд тэсэлгээний ажил гүйцэтгэж байгаа “Эрхэт түнш”ХХК-нд тэсрэх материал нийлүүлэх, Цанхийн Баруун уурхай, “Таван толгой”ХК-ний уурхайнууд болон Ноён суманд үйл ажиллагаа явуулж буй “Терра Энержи”ХХК-ний нүүрсний уурхайнуудад тэсэлгээний ажил, үйлчилгээг гүйцэтгэн ажилласан болно. 2019 онд өнгөрсөн жил хамтран ажилласан аж ахуйн нэгж, байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтарч ажиллах төлөвлөгөөтэй байгаа ба тэсрэх бодисын үйлдвэрлэлийн ажил, үйлчилгээ хэвийн явагдах төлөвтэй байгаа болно. Иймд 2019 онд энэхүү “Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө”-нд тусгасан ажлуудыг өөрийн дотоод нөөц бололцоог болон орон нутгийн удирдлага, ард иргэдийн оролцоотойгоор хэвийн явуулахаар төлөвлөн ажилласан. “Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ”-г 2024 онд “Хас цаг” ХХК-р гүйцэтгүүлэн БОУАӨЯ-р батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.

1.8 Цаашид хэдэн жил үйл ажиллагаа явуулах боломжтой тухай :

Тус төсөл нь Таван Толгойн нүүрсний орд газар дээр уурхайн олборлолт явагдаж байгаа нөхцөлд хэвийн, тасралтгүй үргэлжлэх боломжтой боловч дан эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх үйл ажиллагаа нь улсын хэмжээнд уул уурхайн олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа тогтвортой биш байгаатай холбогдон байнгын ажиллах боломж бага байгаа болно. Иймд компанийн зүгээс үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөтгөн энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байна. Манай компанийн төсөл хэрэгжүүлж байгаа орчинд буюу Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах “Эрдэнэс Таван Толгой”ХХК, “Таван толгой”ХК, “Энержи Ресурс”ХХК-иудын нүүрсний уурхайн төслүүдийн ашиглалтын Техник Эдийн Засгийн Үндэслэл нь 23 жилээр төлөвлөгдсөн байдаг бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг даган уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигд хэвийн явагдах нөхцөлд зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах бодлого баримтлан ажиллаж байна. Манай компанийн зүгээс тэсэлгээний ажил, үйлчилгээний чиглэлээр зах зээлээ өргөжүүлэх, харилцагчидаа нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба цаашдаа тэсрэх материалын худалдаа, борлуулалт, тэсэлгээний ажил, үйлчилгээг зөвхөн тухайн бүс нутагт төдийгүй Монгол орны аль ч аймаг, орон нутагт хүргэх боломж, нөхцлийг судлан ажиллаж байна.

1.9 Техник тоног төхөөрөмжийн тухай:

“Спейшл Майнинг Сервис”ХХК-ний “Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис үйлдвэрлэх, худалдаалах, үйлчилгээ үзүүлэх” төсөл нь 2018 оны 11 сарын байдлаар дараахь нэр төрлийн техник, төхөөрөмжийг үйлдвэрлэл болон худалдаа, үйлчилгээндээ ашиглаж байна (Хүснэгт 1)

Мөн эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь “Dyno Nobel” компанийн зураг төсөл дээр тулгуурлан АНУ улсын “Tread Corp” компанийн иж бүрэн тоног төхөөрөмж, түүнд зориулан, АНУ-ын “Lubrizon” компанийн эмульсжүүлэгч бүтээгдэхүүний технологи дээр суурилагдсан болно. АНУ улсын “Tread Corp” компанийн 3216 маркын цэнэглэгч биеийг Scania маркын ачигч 6x4 машин дээр суурилуулан ашиглаж байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж буй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт:

Хүснэгт 1. Машин техникийн жагсаалт

№	Техник тоног төхөөрөмж	Хэмжээ, даац	Тоо	Тайлбар
1	Эмульс цэнэглэгч машин	12 тн	1	Тусгай зөвшөөрөлтэй
2	Эмульс цэнэглэгч машин	14 тн	3	Тусгай зөвшөөрөлтэй
3	ANFO буюу хуурай цэнэглэгч машин	16 тн	1	Тусгай зөвшөөрөлтэй
4	Тэсрэх материал болон химийн бодис, тээвэрлэх зориулалттай ачааны автомашин- /ЮАМОО/	15тн	1	Тусгай зөвшөөрөлтэй
5	Тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зориулалттай бага оврын ачааны машин- /Рюк-ир /	2-4 хүн	4	Тусгай зөвшөөрөлтэй
6	Тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зориулалттай ачааны машин-/Вопдо/	1тн	1	Тусгай зөвшөөрөлтэй
7	Шингэн эмульс тээвэрлэх	32,5тн	2	Тусгай зөвшөөрөлтэй
8	Telehandler/ сэрээт өргөгч /	1,5тн	1	Үйлдвэрлэлд хэрэглэх
9	Forklift / сэрээт өргөгч /	1тн	1	Үйлдвэрлэлд хэрэглэх
10	Bob cut / жижиг оврын ачигч /	0,5тн	1	Үйлдвэрлэлд хэрэглэх
11	Үйлчилгээний суудлын машин / Long 76/	5 хүний	1	Үйлчилгээний автомашин
12	Үйлчилгээний суудлын машин /Long 70/	8 хүний	1	Үйлчилгээний автомашин
13	Ford 450 бага оврын ачааны автомашин	5хүн, 1тн	1	Үйлчилгээний автомашин
14	Манипуляторт крантай ачааны машин /Mighty/	2тн	1	Үйлдвэрлэл, үйлчилгээний
15	Ачааны автомашин /Mighty/	4тн	1	Үйлчилгээний автомашин

1.10 Технологийн дараалал:

Аммиакийн шүү уусгах ба уусмал хадгалах модуль

Модуль нь аммиакийн шүү уусгах болон исэлдүүлэгчийн бэлэн уусмал хадгалах зориулалттай нөөцийн сав юм. Энэхүү нөөцийн сав нь дараах техникийн үзүүлэлттэй:

- Уусмалын шүлтлэг (pH) нь 3.59-3.61 болтол цууны хучил (Acetic Acid) болон содын давс нэмж өгнө. Acetic Acid 60%-75%, Ус 40%-25%
- Уусмалын хийжүүлэгч чанарыг катализжуулхад Thiourea($\text{CH}_4\text{N}_2\text{S}$) нэмж өгнө
- Усыг уусмалын тогоонд хийж цельсийн 40 градус болтол халаана. Үргэлжлүүлэн аммиакын шүүг бага багаар нэмж, үргэлж хутгах байдлаар уусгах ба халууныг 15 градусаас доош буулгаж болохгүй. Ийнхүү аммиакын шүү хийж хутгах байдалд 55 градус болтол халаана. Уусмал аяндаа жигд өтгөрч, түүний дусал үүсгэх цэг (fudge point) нь 44-46 градуст бүрэлдэнэ.

Эмульс бэлтгэх модуль:

Эмульс бэлтгэх ажлыг уусмалын фазаас эхлэн түүнээс насосоор соруулан бэлтгэх тогоонд юүлэнэ. Уусмал юүлэгдмэгц эмульс бэлтгэх ажлын насосыг ажиллуулан уусмалыг эргэлтэнд оруулна. Ийнхүү түлш ба уусмалын фаз холигдон жигд өтгөн байдалд ормогц буцаан эмульс хадгалах тогоонд шахна. Ийнхүү эмульс хадгалах тогоог хаалтаар нь хааж түүний өтгөрөлтийг шалгаж үзнэ

Тосны модуль

Дулаан тусгаарлагч бүхий үлээгч салхилуур, уурын халаагч зэргээр тоноглогдсон модульд доорх 3 модуль байрлана:

- Эрчим хүчний модуль А
- Цахилгааны модуль В
- Тосны модуль С

Ус болон хийжүүлэгч нэмэгдлийн модуль

Эмульсийн үйлдвэрийн ус хангамж нь нэгдсэн нэг системтэй байна. Ус цооногоос гүний насосоор Усны модуль руу шахагдах ба энд ус цэвэрлэх системийн тусламжтайгаар цэвэрлэгдэж, химийн найрлагаараа унданд хэрэглэхүйц чанартай болно. Усыг шаардлагатай хэмд хүртэл халааж, тэнд байрлах насоснуудын тусламжтайгаар модульт, хольж эмульсжүүлэх зөөврийн төхөөрөмж, цэнэглэгч машиныг ачаалах талбай зэргийг усаар хангана.

Дулаан тусгаарлагчтай модуль нь цооногоос ирж байгаа усыг цэвэрлэх, модуль

дахь исэлдүүлэгчийн уусмал бэлтгэх зэрэг үйлдвэрлэлийн технологийн бүх хэрэгцээний болон цэнэглэгч машинд өгөхөөс өмнө бэлтгэж халаах, түүнчлэн хийжүүлэгч нэмэгдлийг цэнэглэгч машинд халааж өгөхөд зориулагдсан болно.

Модуль нь хаалтаар тусгаарлагдсан 2 хэсгээс бүрдэнэ: Үүнд:

Ус цэвэрлэх болон халаах модуль:

Цэнэглэгч машинд ачаалах хийжүүлэгч нэмэгдлийг бэлтгэх модуль:

Байнгын арга хэмжээ: Уусмал нь дамжуулах шугам болон насос зэрэг эд ангиудад өтгөрч хатууран бөглөрөл үүсгэх ба үүнээс болгоомжилж ус гүйлгэн байнга булхан угааж байх шаардлагатай

Эцсийн бүтээгдэхүүн: Ийнхүү дээр дүрсэлсэн байдлаар эмульс бэлтгэж авах ба дараа нь тусгай зориулалтын насосоор дамжуулан цооног цэнэглэх зориулалтын төхөөрөмжийг хэрэгцээний хэмжээгээр дүүргэж цооног цэнэглэхэд бэлтгэнэ.


Зураг 4. Тэсрэх бодисын үйлдвэр, түүхий эдийн агуулахын зураг



Зураг 5. Тэсрэх бодисын үйлдвэрийн дотоод зохион байгуулалт.



Зураг 6. Флоу-чарт диаграм



2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл

Агаар: Тус үйлдвэрийг ашиглах явцад их хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан хүн ам, амьтан, ургамал, хөрс, усанд нөлөөлөхүйц хэмжээний сөрөг нөлөөлөл үүсээгүй боловч дараах багахан хэмжээний сөрөг нөлөөллүүд үүссэн болно.

- Салхины хүч, агаарын чийг, тээврийн үйл ажиллагаанаас хамааран агаар мандалд гарах тоосны хэмжээ хуурайшлын үед нэмэгдэх, зөөгдөх,
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэх нь агаарын чанар, шуугианы бохирдлын түвшинг ихэсгэнэ.
- Үйлдвэрлэлд ашиглагдаж буй химийн бодисуудаас эвгүй үнэр агаарт тархах зэрэг болно.

Газрын гадарга, хөрс: Тэсрэх бодисын үйлдвэр, аммиакийн шүүний буюу түүхий эдийн агуулах, тэсрэх материалын агуулахын цогцолбор нь 5га талбайг тойруулан татсан хашаан дотор байрлах ба уг 5 га талбайн хөрс болон газрын гадарга тодорхой хэмжээгээр нөлөөлөлд өртсөн. Мөн тээвэр зөөвөртэй холбогдон хөрс, ургамлан бүрхэвч бага хэмжээгээр өртсөн ба “Эрдэнэс Таван Толгой”ХХК-ний уурхай руу тэсрэх материалын тээвэрлэлт хийхдээ зөвхөн Цогтцэций сумаас уурхай явсан технологийн замаар тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа болно. Ус: Ахуйн болон технологийн хатуу болон шингэн хог хаягдлыг дүрэм, журам, стандартын дагуу зайлуулснаар гүний усанд сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно.2013 оноос хойш үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цогтцэций багт орших “Ухаа худаг ус хангамж” ХХК-иас зөөврөөр гүний усыг ашиглаж байсан бөгөөд 2017 оноос үйлдвэрийн хашаан дотор өөрийн эзэмшлийн гүний худаг гарган үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглаж байна.

Ургамал: Тээврийн хэрэгсэл болон хүний үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг талхлагдаж улмаар хөл газрын ургамал тархах болсон.

Амьтан: Тээврийн хэрэгслийн дуу чимээ, үйлдвэрлэл явагдаж байх үеийн техникийн болон хүний хөдөлгөөний үед тухайн газрын хөрсний амьд организм, шавьж дайжин устаж үгүй болсон.

Хатуу хог хаягдал, аюултай болон хорттой хаягдал :

“Спейшл Майнинг Сервис”ХХК нь 2018 онд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг “Тэгш дүүрэн тохижилт”ОНӨААТҮГ- тай хамтран ажиллах гэрээ

байгуулан, хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, төвлөрсөн цэгт хүргэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан ба 2020 онд мөн тус байгууллагатай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас болон бусад шалтгаанаар аюултай хог хаягдал гарсан тохиолдолд орон нутгийн болон улсын холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, устгуулах ажлыг зохион байгуулж ажиллахаар төлөвлөсөн болно.

Аюул гамшиг, осол, эрсдэлийн тухай тэмдэглэл:

Төсөл хэрэгжүүлж эхэлснээс хойшхи хугацаанд ямар нэгэн аюул, гамшиг, осол, эрсдэлд өртөөгүй мөн түүнтэй холбоотой асуудал гараагүй бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г мэргэжлийн байгууллагаар буюу Өмнөговь аймгийн Онцгой Байдлын Газраар батлуулан, тогтмол хянуулж, хамтран ажиллаж байна.

Мөн манай компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа Цогтцэций суманд байрлах Гал унтраах, аврах 44-р ангитай нягт хамтран ажиллаж, сургалт, арга зүйн зөвлөгөөг тогтмол авч ажиллаж байгаа болно.

Үүсэж болох эрсдлийг тооцож, болзошгүй аюул ослын үед авах хариу арга хэмжээнүүд

Тэсрэх бодисын үйлдвэрийн удирдлага аливаа осол тохиолдлоос ямагт сэргийлж болно гэсэн итгэлээр үйл ажиллагааныхаа хүрээнд урьдчилан сэргийлэх бүх боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэхдээ осол болсон тохиолдолд үйлдвэрийн удирдлага учирсан осол тохиолдлыг:

1-рт Хүн:

2-рт Байгаль орчин:

3-рт Өмч:

гэсэн эрэмбээр ослын тохиолдлыг цаашид хүндрүүлэхгүй яаралтай арилгах, ослоос урьдчилан сэргийлэх тодорхой үр дүнтэй төлөвлөгөө буюу үйлдвэрийн “Аваарь устгах төлөвлөгөө”-ний дагуу бэлэн байдалд байлгана.

Онцгой байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө нь тусгайлан бие даасан албан ёсны бичиг баримт буюу холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулсан “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” байх бөгөөд үүнтэй холбоотой онол, практикийн сургалтуудыг Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн болон Байгаль орчны хэсгийн ажилтнууд

тогтмол явуулах ба мэргэжлийн байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулж ажиллана.

“Спейшл Майнинг Сервис”ХХК-нь үйлдвэрлэл, үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлж ажиллах “Гамшгаас Хамгаалах Төлөвлөгөө”-г Өмнөговь аймгийн Онцгой Байдлын Газраар батлуулан ажиллаж байгаа болно. Мөн үйлдвэр агуулахын цогцолборт хэрэгжүүлэн ажиллах “Аваарь устгах төлөвлөгөө”-г дотоод үйл ажиллагаандаа батлан хяналт тавьж, хэрэгжүүлж байна.

Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ)

"Спейшл Майнинг Сервис" ХХК нь “Байгаль орчны удирдлагын тогтолцоо - Шаардлага, хэрэглэх арга заавар М^А8 180 14001:2005 буюу Олон улсын 180 14001 стандартын шаардлагыг хангасан байгаль орчинд ээлтэй байгууллага болох зорилтын дагуу холбогдох, дүрэм, журам, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Байгаль орчны удирдлагын тогтолцооны хүрээнд үйлдвэрлэлийн болон өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дараахь журмуудыг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ БОМС-ийн удирдамж, үндсэн дүрэм
- ✓ Гэрээт компани болон зочдын байгаль орчны дагаж мөрдөх журам
- ✓ Хог хаягдлын журам
- ✓ Асгаралтын журам
- ✓ Химийн бодис материалтай харьцах журмууд
- ✓ Химийн бодисуудын хор аюулын лавлах мэдээлэл
- ✓ Химийн бодисуудын лавлагаа
- ✓ Тэсрэх бодис, тэслэх хэрэгслийн лавлагаа, аюулын мэдээлэл
- ✓ Эмульс үйлдвэрлэлийн стандарт ажлын журмууд
- ✓ Байгаль орчныг хамгаалах талаархи хууль, дүрэм, журмуудын сургалт, зааварчилгаа
- ✓ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой стандарт ажлын журмууд зэрэг баримт бичгийг үйлдвэрлэлийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн 2018 онд манай компани Чанарын Удирдлагын Тогтолцоо / ISO

9001:2015 / болон Хөдөлмөрийн Эрүүл Мэнд Аюулгүй Байдлын удирдлагын тогтолцоо

/ MNS OSHAS 18001:2012 / зэргийг үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж, баталгаажуулалтаа аван ажиллаж байна.

Цаашид олон улсын стандартын шаардлагын хүрээнд ISO 45001-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зайлшгүй шаардлагын хүрээнд тус стандартад заагдсан байгаль орчны асуудлуудыг стандартын шаардлагын дагуу хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Байгаль орчны сургалт, сурталчилгаа:

Үйлдвэрт очиж буй үндсэн болон гэрээт компанийн ажилтнууд, зочидыг байгаль орчны зааварчилгаа, сургалтад заавал хамруулж бүртгэл хөтөлдөг.

- Байгаль орчны сургалтын зорилго нь Байгаль орчны талаар мөрдөж буй хууль, дүрэм, журмуудыг компанийн үндсэн ажилтан болон гэрээт байгууллагын ажилчдад танилцуулж мөрдүүлэх, үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл, зорилгыг танилцуулах
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг мэдээлэх, ажилчдын үүрэг оролцоог таниулах, үр дүнг хянах зэрэг болно.
- Үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа химийн бодисуудын хор, аюулын талаархи мэдлэг олгох, химийн бодистой зөв харьцаж ажиллах дадал, зуршил эзэмшүүлэх, ашиглалт, хэрэглээнд хяналт тавих, бүртгэх, хадгалалт, хамгаалалттай холбоотой мэдээллээр хангах зэрэг сургалт, зааварчилгааг тухай бүр өгөх
- Мэргэжлийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа “Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтны ХАБЭА-н сургалт”-д үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцож байгаа инженер, техникийн ажилтан, туслах ажилтнуудыг хамруулах

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:

Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-ын сайдын 2019 оны 10- р дүгээр сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу

боловсруулсан болно.

“Спейшл Майнинг Сервис” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь “Тэсрэх бодисын үйлдвэрийн технологи үйл ажиллагаа болон тэсрэх бодис үйлдвэрлэхэд ашиглагдах химийн бодисуудаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах арилгах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, химийн хортой болон аюултай бодисыг зохистой ашиглах талаар зөвлөмж боловсруулах, мөн үйлдвэрлэлийн явцад мөрдөж ажиллах байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр боловсруулан БОАЖЯ-аар баталгаажуулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх” -д оршино.

Энэхүү төлөвлөгөөгөөр үйлдвэр байрлаж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны гол зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарийг тогтоож өгөв.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын болон бүтээн байгуулалтын ажлуудын зардлыг дотоод зардалд тусгахаар төлөвлөсөн болно. Манай компани нь үйлдвэрлэлийн газартаа анх 2013 онд “Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ”-г “Нью ларус”ХХК-р гүйцэтгүүлэн БОАЖЯ-р батлуулан хэрэгжүүлж ажилласан ба 2019 онд “Дэлгэр консалтинг” ХХК-р нэмэлт тодотгол хийлгэхээр гэрээ хийж 2019-2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулсан.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь “Спейшл Майнинг Сервис” ХХК-ийн

“Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын цогцолбор”-ын эргэн тойрны хүрээлэн буй

байгаль орчныг сөрөг нөлөөллөөс хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад чиглэгдсэн болно.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
1	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	Агаарын чанарыг тогтмол хянах, хэмжих	Тэсрэх бодисын үйлдвэр, химийн бодисын агуулах	Төсөл хэрэгжих хугацаанд	ОХШХ тусгав	MNS 5010-2001 Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээг Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014”
2		Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээ авах	Төслийн хэмжээн д	Төсөл хэрэгжих хугацаанд	-	
3		Тэсрэх бодисын үйлдвэрийн ажиллах орчны агаарын чанарын урсгалыг сайжруулах	Төслийн барилга байгуул амж	Жил бүр	Дотоод зардал	
4		Ажлын байр, агуулах, барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах,	Төслийн барилга байгуул амж, агуулах	Төсөл хэрэгжих хугацаанд	500	
5		Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх,	Химийн бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны	Төслийн хэмжээн д	Урьдчилан тооцох боломжгүй	

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
	халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах	дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисын агуулахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах				
6		Сар бүр тэсрэх материал тээвэрлэлтийн чиглэлийг холбогдох байгууллагаар баталгаажуулан мөрдөж ажиллах	Төслийн хэмжээнд	+	Дотоод зардлаар	Аюултай ачаа тээвэрлэх журам
7		Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол,	Төслийн хэмжээнд	+	Дотоод төлөвлөлт өөр	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
		контейнерт хадгалах.				
7	Авто машин, техникийн хөдөлгүүрээс үүсэх хийн бохирдол	Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх	Төслийн хэмжээн Д	+	Дотоод хяналтаар	MNS 0017-5-1-21: 1992 Дуу, чимээ. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх төвшин, хэмжих арга
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УС, УСНЫ ЧАНАР ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
1	Үйлдвэрт ашиглах усыг ариг гамтай хэрэглэх шинэ технологи санаачлага нэвтрүүлэх	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээнд ашигласан усыг тунгаан цэвэршүүлэх, хэмнэх технологи судалж, хэрэгжүүлэх	Төслийн талбайд	Жилд нэг удаа	Үйл ажиллагааны зардлаас	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Тэсэлгээний хорт болон аюултай бодисыг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс бодис алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Төслийн, үйлдвэр болон агуулах орчмыг барихдаа үерийн хамгаалалт, далан байгуулах	Төслийн хэмжээн Д	+	Үйл ажиллагааны зардлаас	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга Усны тухай хууль

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
3	Үйлдвэр, ахуйн бохир ус алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах	Үйлдвэрийн оффис	+	Үйл ажиллагааны зардлаас	
4	Говийн нөхцөл усны нөөц бага тул ариг гамтай хэрэглэх, усны нөөцийг багасахаас сэргийлэх	Ус хэрэглээний бүртгэл хөтөлж, жилд үйлдвэрлэлийн хэрэгцээнд зарцуулсан ус, ажилчдын унд, ахуйн хэрэгцээнд хэрэглэсэн усны тооцоог харьцуулан гаргаж байх	Төслийн хэмжээнд	Улирал бүр	100	Ундны усны эх үүсвэрийг тодорхойлон MNS 0900: 2005 “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
5		Үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдох зам, талбайд ус зайлуулах хоолой болон сувгуудыг зам, талбайн доор байгуулж, богино хугацаанд хуримтлагдах үерийн аливаа усыг зайлуулах	Төслийн хэмжээнд	Тогтмол	100	
УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбайн болон орчны бүсэд	Жилд 1 удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал, аргазүйг баримтална.
2		Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах	Төслийн талбайд	+	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.	
3		Машин механизмыг зориулалтын зам талбайд тавьж, засвар үйлчилгээ хийж, угааж цэвэрлэж байх	Төслийн талбайд	+	Тогтмол хэрэгжүүлэх	
4		Түүхий эд, бүтээгдэхүүний агуулах, зам талбайн хөрс элэгдэж, бохирдохоос хамгаалж бүрэн хамгаалалтын суурьтай болгож тохижуулах	Төслийн талбайд	+	700	
5	Үйлдвэрийн болон орчны талбай дайжих сөрөг нөлөөлөлд өртөх	Амьтан хамгаалах арга хэмжээг зохион байгуулах	+	Жилд 1 удаа	-	Амьтны тухай хууль

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ						
	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбайд	+	ОХШХ-т тусгав.	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850: 2019
	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор зам засвар арчилгаа хийх	Төслийн хэмжээнд	+	Дотоод төлөвлөлт өөр	
	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрс бохирдох	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих	Төслийн хэмжээнд	+	Дотоод зардлаар	MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглахтай холбогдон гарах	Хог хаягдлын сав, цэгийн тохижуулах	Төслийн хэмжээнд	+	Дотоод төлөвлөлт өөр	
	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглахтай холбогдон гарах	Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны гэрэл шууд	Төслийн хэмжээнд	+	Дотоод төлөвлөлт өөр	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” – Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
	нөлөөлөл	тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах				сайдын 54/A/136/A/125 дугаар хамтарсан тушаал
		Тэсэлгээний бодис, материал хүлээн авах талбай, агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл тохиолдолд дор нь засварлах	Төслийн хүрээнд	+	Дотоод төлөвлөлт өөр	
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ						
	Хүний эрүүл мэнд	Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр1 бүрэн хангах	Химийн бодистой	Үйл ажиллагааны туршид	Дотоод зардлаар	- Хөдөлмөрийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа.
		Ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	харьцаж ажиллад аг бүх ажилчид	Үйл ажиллагааны туршид	Дотоод зардлаар	Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000 - Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага.

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг	
		Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр 2 хангах		Үйл ажиллагааны туршид	Дотоод зардлаар	MNS (ISO)13688:2000 Гал түймрээс хамгаалах. MNS 5566 2005	
	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	+	2 жилд 1 удаа	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлт өөр	Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам	
		Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах	+	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлт өөр	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам	
		Үйлдвэр үйл ажиллагаанд 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэх	Тэсрэх бодисын үйлдвэр төслийн хүрээнд		2 жилд 1 удаа	7000.0	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10-р зүйл.
		Байгаль орчны чиглэлийн тэмдэглэлт өдрүүдэд идэвхи санаачлага гарган оролцох	Сум орон нутаг		Жилд 1 удаа	Дотоод зардлаар	
		Нөлөөллийн бүсийн малчин айлд өрхийн малын тоо толгойг харгалзан үзэж өвс тэжээл олгох ажлыг хамтран зохион байгуулах		Нөлөөллийн бүс	Жилд 1 удаа	Дотоод зардлаар	

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал мян	Эрх зүйн баримт бичиг
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ						7700,0

5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, мян ₮	Төрөл	Эрх зүйн баримт бичиг
5.1	Биологийн нөхөн сэргээлт	Нутгийн ургамлын үр, модлог ургамлынн нөөц бүрдүүлэх	Орон нутгаас	кг	10	Жилд	Үйл ажиллагааны зардлаас	Ажил	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 Хөрс хамгаалах,
5.2	Хөрсөн бүрхэвчид	Үндэсний мод	Нөлөөллийн бүсэд	ш	1000	Жилд	10000.0	Ажил	

5.3	үзүүлэх нөлөөлөл	Зөөлөн хөрстэй, элэгдэлд амархан орох зам, талбайг болон ашиглалтын явцад эвдрэлд оржхучаас нь муудсан зам талбайг шигшсэн хайргаар хучиж, олон салаа зам гарахаас сэргийлж сайжруулсан замын арчилгаа тогтмол хийж хусаж янзлах	Нөлөөллийн бүсэд	м	500	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаас	Ажил	цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл. Тэрбум мод үндэсний хөтөлбөр
5.4		Мод тарих талбай хашаажуулах	Нөлөөллийн бүсэд	м	10000	Жилд	500.0	Ажил	
Нийт							10500,0		

5.5 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ Газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ба манай компанийн хэрэгжүүлж буй төслийн талбай болон орчин тойронд одоогоор дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

5.6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчимд нүүлгэн шилжүүлэх шаардлагатай, төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар, малчин айл өрх байхгүй болно.

5.7 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ Тухайн төсөл хэрэгжиж буй орчинд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу төсөл хэрэгжиж буй талбайд археологийн болон палеонтологийн судалгааны ажлыг 2017-онд хийлгэж холбогдох дүгнэлтийг гаргуулсан.Цаашдаа төсөл хэрэгжих явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл холбогдох мэргэжлийн байгууллагуудад болон орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж авран хамгаалах арга хэмжээг зохион байгуулж ажиллана

6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, мян ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6.1	Ажилчид ахуйн хэрэглээнээс гарч байгаа бүх төрлийн хаягдал хамаарна.	Сумаас зохион байгуулж буй их цэвэрлэгээнд хамтран оролцох. Дотооддоо хуваарьт цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах	Нөлөөллийн бүс	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23, 24 дүгээр зүйл, “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам” батлах
6.2		Хог хаягдлын бүртгэлийг хөтлөх, зөвшөөрөлтэй ААНБ-д нийлүүлэх гэрээ байгуулах, хүлээлгэн өгсөн акт үйлдэх	Үйлдвэр		Тогтмол	
6.4		Үйлдвэрийн хог хаягдлын зохицуулалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх	Үйлдвэрт	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	
6.5		Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Үйлдвэрт		Сар бүр	

6.7		Дахивар хүлээн авагчийг судалж хаягдлын төрөл тус бүрээр нийлүүлэх, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин ашиглах ажлыг зохион байгуулах	Үйлдвэрт		Тогтмол	
Аюултай хог хаягдал						
		Үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсний дараа ашигласан химийн бодисын сав баглаа боодлыг ашиглалтын дараа цуглуулж химийн бодис нийлүүлэгчид буцаан тушаах эсхүл эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу аюулгүй газарт хадгалах	Ашигласан материалын уут сав, олгой, таар, шуудай гэх мэт	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014”
		Аюултай хог хаягдлыг хадгалах, ангилан ялгах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	-
6.11		Химийн бодисын сав баглаа, хаягдлыг их хэмжээгээр хуримтлуулж удаан хугацаагаар хадгалахгүй байх, үйлдвэрээс зохих журмын дагуу материалыг бүрдүүлж хаягдлыг устгуулах тухай хүсэлтийг гаргаж байх	“Спейшлмайнинг серви” ХХК-ийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагаа эрхлэх бүх хугацаанд	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” – Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал

6.12		Ажиллагсдад хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах		Үйл ажиллагааны зардлаас	Жилд нэг удаа	
------	--	--	--	--------------------------	---------------	--

7. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Төрөл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7.1		Химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалж, химийн бодисын хадгалалт, ашиглалт, зарцуулалтад тогтмол хяналт тавьж ажиллана.	Агуулах	-	-	Байнга		Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд,
7.2	Химийн бодисыг хадгалах	Хадгалж байгаа бодисын сав, баглаа боодолд тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тод, томруун бичсэн хаяг шошготой байлгаж харагдахуйц байрлалд тодоор зурж байрлуулж тогтмол хяналт тавьж байна	Агуулах	ш	-	Тухай бүр		Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5029 - 2011 Химийн хорт болон аюултай бодисын ш ошго, анхааруулах тэмдэг MNS 6458-2014
7.3		Агуулахад хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна	Нийт химийн бодисын эргэлтэнд	-	-	-	-	

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Төрөл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7.4	Химийн бодис тээвэрлэх	Химийн бодисыг техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэж уг тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлуулна.	Нийт тээврийн хэрэгслүү дэд	ш	-	Байнгын бэлэн байлгах		Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт. 28/40/29. 2009.MNS 4992- 2000
7.5		Химийн бодисыг тээвэрлэж буй авто машины жолооч, ажилтнуудад химийн бодис тээвэрлэж байгаа талаар тодорхой мэдээлэл өгч байхаас гадна тээвэрлэхдээ аюул осол гарсан үед яаралтай ямар арга хэмжээ авах талаар зааварчлагааг тухай бүр өгнө.	Нийт жолооч оператор уудад	ш	-	Байнга		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5029 - 2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Төрөл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7.6		Химийн бодис тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэлд сайтар угаалга, цэвэрлэгээ хийж, зохих шаардлагын дагуу хоргүйжүүлэх арга хэмжээ авч аюулгүй болгоно.	Тэсрэх бодис тээврийн машинууд	ш	-	Байнга		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
7.7		Химийн бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд тогтмол явуулна.	Үйлдвэр	-	-	Байнгын бэлэн байх		Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам.
7.8	Химийн бодис ашиглах	Химийн бодистой харьцах ажилд мэргэжлийн зохих мэдлэг, дадлага туршлагатай 18-аас дээш настай хүнийг ажиллуулна.	Үйлдвэр	-	-	Байнга		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5029 - 2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Төрөл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7.9		Химийн бодистой харьцах үйлдвэрийн ажилчдад аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтыг компани дотооддоо болон холбогдох журамд заасны дагуу мэргэжлийн байгууллага /хүн/ -аар зохион байгуулгуулж, хамтран ажиллана.	Нийт ажилчдад	-	2	Жилд 2	Сургалт	MNS 4969 - 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм
7.10		Химийн бодис ашиглах явцдаа байгаль орчинд болон ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бохирдол гаргасан тохиолдолд бохирдлыг бууруулах, арилгах, саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Төслийн хэмжээнд	-	-	Байнгын бэлэн байлгах	-	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5029 - 2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Төрөл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7.11		Химийн бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон цэгт хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хоргүй буюу аюулгүй аргаар Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу устгана.	Шаардлагатай тохиолдолд		--	Тухай үед	-	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт. 28/40/29. 2009.

8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая ₮	Төрөл	Баримтлах стандарт, арга, аргачлал
8.1 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ								
8.1.1	Гадаад орчны дуу шуугианы хэмжилт	Тэсэлгээний талбай	Жилийн турш	14 хоног бүр	- - -	- - -	Ажил/Дүрэм	MNS 4585:2016 Монгол улсын агаарын чанарын стандарт

8.1.2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	Үйлдвэр	Жилд 2	2	160	160	NO ₂ , SO ₂ , H ₂ S, CO, VOCs- BTEX) CO ₂	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885:2008/
8.2 УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ								
8.2.1	ГДУ геохимийн судалгаа: Макро, микро элемент	Үйлдвэр №6	Жилд 2	2	140	140	HCO ₃ , SO ₄ , CL, Na, K, Mg, Ca бусад	MNS 0900:2018
8.3 ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХЯНАЛТ								
8.3.1	Хөрсний чанар – Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Үйлдвэрийн	Жилд	2 удаа	160	160	Үйлдвэр	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
		Оффис			160	160		
		Шалган нэвтрүүлэх байр			160	160		
8.3.2	Хөрсний чанар – Хүнд металлын шинжилгээ	Үйлдвэр	Улирал	1 удаа	220	220	Хөрсөн дэх хүнд металлийн бохирдол тодорхойлох	

8.3.3	Нүүрс устөрөгч	Үйлдвэр ШТС	Улирал	1 удаа	75	75	Хөрсөн дэр нефтийн бүтээгдэхүүний бохирдол тодорхойлох
8.3.4	Бохирдсон хөрсний нефтийн бохирдлын шинжилгээ	Бохирдсон хөрс саармагжуулах талбай	Жилд 1	1 удаа	75	75	Бохирдсон хөрсний саармагжсан байдлыг тодорхойлох
Нийт						2175,0	

10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.

№	БОМТ ангилал	Төсөв, мян₮
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7700,0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10500,0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас
4	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2175,0
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас
	Нийт	20375,0